

ЦАХИМ СУРГАЛТАНД ВИРТУАЛ ХИЧЭЭЛИЙГ АШИГЛАХ БОЛОМЖ

Х.Оюунбаяр¹, Д.Мөнх-Эрдэнэ¹

¹АШУУИС, Дархан АУСургууль
oyunbayar@mnums.edu.mn

Хураангуй

Өөрчлөгдөн хувьсаж буй боловсролын технологийн өнөөгийн эрин үед цахим сургалтын олон хэлбэрүүдийг сургалтанд ашиглах нь үр дүнтэй, өгөөжтэй үйл ажиллагаа билээ. Ковид-19 цар тахлын үед зайнаас зохион байгуулсан цахим сургалтын үед виртуаль хичээл ашиглан ур чадвар эзэмшүүлэх, үнэлэх зорилгоор төгсөх дамжааны оюутнуудыг хамруулан уг ажлыг хийлээ. Сургалтын үр дүнг онооны системээр үнэлж, дундаж болон стандарт хазайлтыг тодорхойлон үр дүнг хүснэгт, графикаар илэрхийлэв. Судалгааны үр дүнд виртуал хичээлд оюутнууд эерэг хандаж байгаа нь харагдсан бөгөөд эх хэлээрээ зохиогдсон, олон төрлийн виртуал хичээлийн сантай болох шаардлагатай байгаа нь харагдлаа.

Түлхүүр үг: Цахим сургалт, виртуаль хичээл, мэргэжлийн ур чадвар

Үндэслэл:

ЮНЕСКО-ийн мэдээлснээр Covid-19 цар тахлын улмаас боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа анги, танхимд явагдах боломжгүй болж сургуулиа хаасан улсын тоо 2020 оны 3-р сарын 15-нд 53, 4-р сарын 15-нд 190, 5-р сарын 15-ны байдлаар 158 болсон байна. Цар тахлын тархалтын оргил үед дэлхийн нийт суралцагчдын 91.3 хувь нь сургуульд явах боломжгүй, онлайн болон бусад ямар нэгэн хэлбэрээр сургалтаа үргэлжлүүлж, зарим улсад хязгаарлагдмал боломжоос хамаарч сургалт зогсоход хүрсэн байна.

Монгол Улсад, түүн дотроос АШУУИСургууль 2019-2020 оны хичээлийн жилийн хоёрдугаар улиралд цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Анагаахын чиглэлийн дээд боловсролын хөтөлбөрүүдийн хичээл хоорондын залгамж хамаарал, багшийн цахим хичээл боловсруулах технологи, орчин нөхцөл, түгээх програмаас хамаарч цахим сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүн суралцагчдын ур чадварт сөргөөр нөлөөлөх боломжтой. Энэ нөлөөллийг багасгах, чадваржуулах сургалтыг чанаржуулахад виртуаль сургалтыг ашиглах нь тодорхой үр дүнг үзүүлэх боломжтой юм.

Чадамжийг олгоход сургалтын орчин чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд олон тооны лаборатори, тусгай тоног төхөөрөмжүүд, асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах нь дамжиггүй юм. Ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг

хангахуйц мэдлэг, чадвар, хандлага бүхий мэргэжилтэнг бэлтгэн гаргахад шаардагдах энэхүү хөрөнгө, санхүүгийн нөөцийг боловсролын байгууллага бүр бүрдүүлэн бий болоход гардаг хүндрэлийг даван туулах зорилгоор дэлхий нийтэд ашиглаж буй виртуал лабораторийг бий болгох нь бидний хэрэгжүүлэх зайлшгүй алхам нэг болоод байна.

Орчин үеийн мультимедиа технологийг ашиглан хийсвэр ухагдхуунууд болон төсөөлөх, харахад төвөгтэй зүйлсийг бодит юм шиг харагдуулж амьдруулснаар хичээлийг ойлгомжтой, илүү сонирхолтой болгоод зогсохгүй онолын хэсгийг заах хугацааг багасгаж, суралцагчдын дадлага хийх цагийг нэмэгдүүлэх боломж олгоно. Мэдээллийг олон янзаар хүлээж авдаг ба мэдээллийг хүлээн авах чадвар илүү хөгжсөн онцлогтой, индукци сэтгэлгээтэй монгол хүний хувьд виртуаль орчинд сургалт явуулах нь илүү өгөөжтэй байх магадлалтай.

Зорилго: Цахим сургалтанд виртуаль хичээл ашиглах давуу талыг үнэлэх

Зорилт:

1. Цахим сургалтанд ашиглах виртуаль хичээлийн чиглэлийг тодорхойлох
2. Виртуаль дадлагын хичээл явуулж оюутны ур чадварыг үнэлэх
3. Виртуаль болон танхимийн дадлагын хичээлийн ур чадварын үнэлгээг харьцуулах

Шинэлэг тал ба практик ач холбогдол

Цахим сургалтанд виртуаль хичээл ашиглах боломжийг судлах, цахим сургалтын өгөөжийг дээшлүүлэх, оюутны ур чадварын сургалтанд ашиглах хэрэглэгдхүүний нөөцийг баяжуулах

Судалгааны арга зүй:

Судалгааг явуулахдаа нэг агшны судалгааны анкет судалгааны арга, баримт бичгийн судалгааны арга ашиглан мэдээллийг цуглуулж, статистик боловсруулалтыг MS EXCEL, SPSS-25 программаар хийлээ.

Виртуаль сургалтын орчинд оюутнуудын хандах байдлыг тандах зорилгоор тус сургуулийн Шаталсан сургалттай эм найруулагчийн хоёрдугаар дамжаа, эм найруулагчийн гуравдугаар дамжааны нийт 32 оюутанд ОХУ-ын Пермь хотын Эм зүйн академийн виртуаль хичээлээс жишээлэн үзүүлж, асуумж авлаа.

Судалгааны ажлын үр дүн ба хэлцэмж:

1. Цахим сургалтанд ашиглах виртуаль дадлагын хичээлийн чиглэлийг тандах асуумжинд эмийн сангийн зохион байгуулалт, Эмийн ургамал судлал, эмийн технологийн хичээл гэсэн дарааллаар сонгосон байв. Судалгаанд Эмийн сангийн зохион байгуулалт хичээлийн зөвхөн нэг дадлагын орос хэл дээрх хичээлийг ашигласан тул оролцогчдын зүгээс ойлгомжгүй байна, өөр бусад хичээл дээр гардан үйлдэл шаардлагатай сэдэв бүрээр виртуал хичээлтэй бол сайн байна гэсэн санал хүсэлт бичсэн байлаа.
2. Виртуаль дадлагын хичээлээр олгосон гардан үйлдлийн үр чадварын дундаж үнэлгээ $2,84 \pm 1,27$ байлаа.

Гардан үйлдлийн үр чадварын үнэлгээ

	Average	STDev
Виртуаль хичээл	2.84	± 1.27

3. Виртуаль дадлагын хичээлээр олгосон гардан үйлдлийн үр чадварын дундаж үнэлгээг өнгөрсөн хичээлийн жилийн төгсөлтийн өмнөх үйлдвэрлэлийн дадлагын гардан үйлдлийн үр чадварын үнэлгээтэй харьцуулж үзэхэд 1,06 оноогоор доогуур байлаа. Цахим хичээлийг бүрэн судалсан оюутнуудын гардан үйлдлийн дундаж оноо нь 3,65 байсан нь төгсөлтийн өмнөх үйлдвэрлэлийн дадлагын үр чадварын үнэлгээний оноотой ойролцоо байлаа. Цахим хичээлийн виртуаль дадлагын хичээлийг үзэх интернетийн хурд болон төхөөрөмж дутагдалтай байсан оюутнууд доогуур үнэлгээтэй байлаа.

Дүгнэлт:

Цахим сургалтанд виртуаль лаборатори шаардлагатай эсэхэд бүх оюутан эерэг хандсан бөгөөд онолын мэдлэгийг бататгах, ойлгоогүй зүйлээ олон дахин давтах судлах боломжтой, үр чадварын үйлдлүүдэд суралцах, давтах, багшийн үнэлгээг бодитой болгох зэрэг олон давуу талтай болох нь ажиглагдлаа. Интернетийн хурд, виртуал хичээл судлах боломжтой төхөөрөмжийн хангамж зэрэг нь оюутны эзэмших үр чадварт шууд нөлөөлөх нь харагдлаа. Оюутны төрөлх хэл дээр хийгдсэн, тухайн хичээлийн агуулга бүрд харгалзах виртуаль хичээлийн сантай болох шаардлагатай байна.

THE POSSIBILITY OF USING VIRTUAL CLASSROOMS IN DISTANCE LEARNING**Abstract**

Today, in evolving era of educational technology, the use of many forms of e-learning in education technology is effective and rewarding. The work was carried out with the aim of assessing the acquired skills of graduates using virtual lessons during a distance learning course during the Covid-19 pandemic. Learning outcomes were assessed using a scoring system, mean and standard deviations were determined, the results were expressed in tables and graphs. The survey showed that students have a positive attitude towards virtual classes and there is a need for a variety of virtual lessons in their native language.

Key words: e-learning, virtual class, professional skills

Ном зүй:

1. Монгол улсын Боловсролын тухай хууль
2. Монгол улсын “Цахим монгол” хөтөлбөр
3. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн электрон сургалтын хөтөлбөр
4. АШУҮИС. Дархан АУСургуулийн урт хугацааны стратеги төлөвлөгөө
5. Никулина Т.В., Стариченко Е.Б. (2016) Виртуальные образовательные лаборатории: Принципы и возможности. Педагогическое образование в России. №7
6. Гурьянов П.С., Чикин Т.В. Проект лаборатории виртуальной реальности для подготовки фармацевтических специалистов. <https://guri-anov-pavel.livejournal.com/86107.html>
7. Саданова Б.М., и др. (2016) Применение возможностей виртуальных лаборатории в учебном процессе технического ВУЗа. Молодой ученый. №4. стр.71-74
8. Түвшинбаяр А. (2015) Виртуал бодит байдлын системүүдийн судалгаа. ШУТИС. Дархан Технологийн сургууль. “CDIO сургалтын дэвшилтэт аргыг нэвтрүүлэх боломж” ЭШХурлын эмхэтгэл.
9. Ургамалсүвд Д., Түвшинбаяр А. (2015) Сургалтанд виртуал лабораторийн хэрэглээ, ач холбогдол. “CDIO сургалтын дэвшилтэт аргыг нэвтрүүлэх боломж” ЭШХурлын эмхэтгэл.